



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/401.

Улаанбаатар хот

“Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын” эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн биеийн тамир, спортын газрын эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 14 нэр төрлийн нийт 22,659,630.20 (хорин хоёр сая зургаан зуун тавин есөн мянга зургаан зуун гучин төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газар (Ж.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

2.Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 4 нэр төрлийн нийт 321,640.20 (гурван зуун хорин нэгэн мянга зургаан зуун дөчин төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөх, 10 нэр төрлийн 22,337,990.00 (хорин хоёр сая гурван зуун гучин долоон мянга есөн зуун ерэн) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 370,000.00 (гурван зуун далан мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 111,000.00 (нэг зуун арван нэгэн мянга) төгрөгийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Биеийн тамир спортын газар (Ж.Ганболд)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В. Оюумаа

В.ОЮУМАА

1150501100

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 30 -ны өдрийн 1401 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн биеийн тамир спортын газар

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан гийг	Хэмжих жлг	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын санал	Мэргэжилтний санал	ҮХХХК-ын шийдвэр
1.Машин тоног төхөөрөмж													
1	Компьютер	6	ш	1	2,135,000.00	2,135,000.00	2,135,000.00	-	эвдэрсэн	актлах		20,000.00	20,000.00
2	Принтер	12	ш	1	429,000.00	429,000.00	429,000.00	-	эвдэрсэн	актлах		10,000.00	10,000.00
3	Принтер	12	ш	1	275,000.00	275,000.00	275,000.00	-	эвдэрсэн	актлах		10,000.00	10,000.00
4	Принтер	5	ш	1	165,000.00	165,000.00	165,000.00	-	эвдэрсэн	актлах		10,000.00	10,000.00
5	Компьютер	12	ш	10	1,529,000.00	15,290,000.00	15,290,000.00	-	эвдэрсэн	актлах		150,000.00	150,000.00
6	Факсын аппарат	19	ш	1	149,990.00	149,990.00	149,990.00	-	эвдэрсэн	актлах		5,000.00	5,000.00
	машин тоног төхөөрөмжийн дүн				18,443,990.00	18,443,990.00	18,443,990.00					205,000.00	205,000.00
Тавилга, эд хогшил													
1	Оффисын ширээ	12	ш	8	165,000.00	1,320,000.00	1,320,000.00	-	эвдэрсэн	актлах		80,000.00	80,000.00
2	Бичиг хөргийн шүүгээ	12	ш	1	286,000.00	286,000.00	286,000.00	-	эвдэрсэн	актлах		15,000.00	15,000.00
3	Сейф төмөр	50	ш	1	110,349.00	110,349.00	110,349.00	-	ашиглагдахгүй болсон	актлах		татах	татах
4	Сейф төмөр	55	ш	1	98,228.70	98,228.70	98,228.70	-	ашиглагдахгүй болсон	актлах		татах	татах
5	Сейф төмөр	50	ш	1	72,360.00	72,360.00	72,360.00	-	ашиглагдахгүй болсон	актлах		татах	татах
6	Сейф төмөр	50	ш	1	40,702.50	40,702.50	40,702.50	-	ашиглагдахгүй болсон	актлах		татах	татах
7	Хурлын ширээ	12	ш	1	1,320,000.00	1,320,000.00	1,320,000.00	-	эвдэрсэн	актлах		30,000.00	30,000.00
8	Ширээний шүүгээ	12	ш	8	121,000.00	968,000.00	968,000.00	-	эвдэрсэн	актлах		40,000.00	40,000.00
	Тавилга эд хогшлын дүн				4,215,640.20	4,215,640.20	4,215,640.20					165,000.00	165,000.00
Нийт дүн													
	Үүнээс: Худалдан борлуулах хөрөнгө				22,659,630.20	22,659,630.20		-				370,000.00	370,000.00
	Татан төвлөрүүлэх				321,640.20								
	Устгах хөрөнгө												
	Худалдсанаас олох орлого				370,000.00								
	НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/				111,000.00								